



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ХОВД АЙМГИЙН АУДИТЫН ГАЗАР

*Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын захиалгаар
Дөргөн сумын төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны үр дүнд хийсэн
гүйцэтгэлийн аудитын тайлан*

**ТӨСВИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТАНД ТАВИХ
ДОТООД ХЯНАЛТ СУЛ БАЙНА.**

Ховд хот

2016 оны 9 сар

Агуулга

Аудитыг гүйцэтгэж тайланг бэлтгэсэн: ҮАГ-ын харьяа Ховд аймгийн аудитын газар	Товчилсон үгийн жагсаалт Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй стандартын талаарх мэдэгдэл	1 2
Тэргүүлэх аудитор Л.Галбадрах Аудитын менежер А.Цэцэгсүрэн Ахлах аудитор Д.Нарантуул Аудитор Д.Эрдэнэцэцэг Шинжээч Б.Дамчуубалжир	Бүлэг 1.Төсөвт байгууллагуудын орлого бүрдүүлэлттийн талаар <i>Орон нутгийн орлогын бүрдүүлэлтэнд тавих хяналт сулаас орон нутгийн орлого 10,1 сая төгрөгөөр тасарчээ.</i>	3 3 4 5 6
2016 оны 9 дүгээр сар Уг тайланг ҮАГ-ын Веб сайтаас үзнэ үү. www.audit.gov.mn Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70432545 дугаарын утас, 70433061 дугаарын факсаар харилцана уу. ХАЯГ: Ховд аймгийн Засаг даргын Тамгын газар Ховд аймгийн Аудитын газар 3 давхар	Бүлэг 2. Төсөвт байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн, хөрөнгийн зарцуулалтын талаар <i>Сумын дүнгээрээ төсвийн санхүүжилтийг баталсан дүнгээс 83,1 сая төгрөгөөр дутуу авч, өөрийн орлогыг 3,7 сая төгрөгөөр тасалжээ.</i> <i>Сумын төсвийн байгууллагуудын төсвийн хөрөнгийн зарцуулалтанд тавих дотоод хянадт сайн байна.</i> <i>Орон нутгийн өмчийн хөрөнгийг ашиглах түрээсийн гэрээ байгуулж өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалтанд тавих хяналтыг сайжруулах шаардлагатай байна</i> Бүлэг 3. Дотоод хяналтын талаар Дотоод хяналтын үр нөлөөт тогтолцоог хэрэгжүүлэн Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна. Аудитын дүгнэлт Аудитын зөвлөмж Тэргүүлэх Аудиторын тушаал Акт албан шаардлагын товчоо Холбогдох байгууллагаас ирүүлсэн санал:	8 10 10 11 12 13 13 14 15 16 18 21

Товчилсон үгийн жагсаалт

УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний Аудитын Газар
ААГ	Аймгийн аудитын газар
БСШУЯ	Боловсрол Соёл Шинжлэх Ухааны яам
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ЗДТГ	Засаг Даргын Тамгын газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
НДШ	Нийгмийн Даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь Хүний Орлогын албан татвар
ТБОНӨХБАҮХА	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ЭЭС	Эмийн эргэлтийн сан
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
Мян.төг	Мянган төгрөг

1.1.Аудит хийх бүрэн эрх, үндэслэл: Аудитыг Аймгийн ИТХ, Засаг даргын захиалга, Монгол Улсын Ерөнхий аудиторт Аймгийн Аудитын Газраас 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон аймгийн Аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд хийлээ.

1.2 Аудитын зорилт, хамрах хүрээ: Дөргөн сумын төсөвт байгууллагуудын 2015 оны үйл ажиллагааны үр дүн, төсвийн хөрөнгийн зарцуулалтанд гүйцэтгэлийн аудит хийж, дүнг аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв.

Аудитын зорилтыг ханган биелүүлэхийн тулд дараахь чиглэлээр аудит хийлээ.

- Орон нутгийн төсвийн байгууллагууд 2015 онд дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлж, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээгээр хүлээсэн үүргээ тоо, чанарын хүрсэн байх түвшинг ханган биелүүлсэн эсэх
- Төсвийн байгууллагуудын төсвийн орлого бүрдүүлэлт, зарцуулалтын явцад нөөцийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй зарцуулах зарчим хэрэгжсэн эсэх
- Дотоод хяналтын үр нөлөөтэй тогтолцоог хэрэгжүүлсэн эсэх

Аудитын зорилтыг ханган биелүүлэхийн сумын Засаг даргатай байгуулсан бүтээгдэхүүн нийлүүлэлт, санхүүжилтийн гэрээ, уг гэрээг дүгнэсэн тухай илтгэх хуудас, Засаг даргын мөрийн хөтөлбөрийн хэрэгжилт үр дүнгийн тайлан, төрийн албан хаагчдийн үр дүнгийн гэрээ, түүний биелэлт үр дүнгийн тайлан, төсвийн байгууллагуудын 2013 оны жилийн эцсийн тайлан тэнцэл, орлого бүрдүүлэлт, зарцуулалтын талаарх санхүүгийн баримт материал, өмч хөрөнгийн жилийн эцсийн тооллогын бүртгэл, өдөр тутмын банкны хуулга, касс, харилцахын гүйлгээ, нягтлан бодох бүртгэлийн туслах, журналууд, дэлгэрэнгүй бүртгэлүүд зэрэг баримт материалыг хамрууллаа.

1.3 Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт, хугацаа: Аудитыг Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудит хийх журам, арга зүйг ашиглаж аудитын дүн, дүгнэлтэнд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох бусад мэдээллийг ажлын баримт материалд хавсаргав.

Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нийгмийн даатгалын болон Татварын багц хуулиуд, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын багц хуулиуд, Хөдөлмөрийн хуулиуд болон аймаг, сумын ИТХ-ын Тэргүүлэгчдийн тогтоол, шийдвэр, журмууд, аймаг, сумын Засаг даргын шийдвэрүүдийг шалгуур болгон ашиглав.

Аудитыг аймгийн Тэргүүлэх аудитор Л.Галбадрах удирдаж, аудитын менежер А.Цэцэгсүрэн, ахлах аудитор Д.Нарантуул, аудитор Д.Эрдэнэцэцэг, шинжээч Б.Дамчуубалжир нар 2016 оны 9 сарын 26-наас 9 сарын 30-ны өдрийг хүртэлхи хугацаанд гүйцэтгэлээ.

Аудитын явцад санал асуулгын хайрцагаар санал хүсэлт ирээгүй бөгөөд төсвийн байгууллагуудын 65 албан хаагчаас санал асуулга авч санал хүсэлт ирүүлсэний дагуу холбогдох горимуудыг хэрэгжүүллээ.

1.4 Аудитын тайлангийн бүтэц, түүнд тусгагдах мэдээлэл: Дөргөн сумын төсөвт орон нутгийн орлого бүрдүүлэлтийн талаар I бүлэгт, Төсөвт байгууллагуудын хөрөнгийн зарцуулалтын талаар II бүлэгт, Дотоод хяналтын талаар III бүлэгт тусган аудитын дүгнэлт, зөвлөмж, холбогдох газрын санал гэсэн агуулгаар бичигдлээ.

БҮЛЭГ 1. ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН, ОРЛОГО БҮРДҮҮЛЭЛТИЙН ТАЛААР

Дөргөн сум нь 2893 хүн амтай, 716 өрхтэй, 126,9 мянган толгой малтай, 412,0 мянган га газар нутагтай, аймгийн төвөөс 103 км, улсын нийслэл Улаанбаатараас 1500 гаруй км алслагдсан, зам харгуй сайтай.

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага ИТХ-тай, төрийн захиргааны байгууллага ЗДТГазар, нийгмийн үйлчилгээний салбар сумын Эрүүл мэндийн төв, 12 жилийн ерөнхий боловсролын сургууль, Цэцэрлэг, Соёлын төв гэсэн төсөвт байгууллагуудтай, ХААН, Төрийн банк, Холбоо, шатахуун түгээх станцууд зэрэг аж ахуйн нэгжтэй. Эрчим хүчний байнгын эх үүсвэр, үүрэн холбооны Мобиком, Скайтель, Жи-мобиль, Юнителийн сүлжээнд холбогдон төрийн үйл ажиллагааг иргэдэд шуурхай хүргэх үүрэгтэйгээр ажиллаж байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагч нь татварын орлогоор 17,7 сая, санхүүгийн дэмжлэгээр 301,9 сая, ОНХС-гийн санхүүжилтээр 113,0 сая, СХС-гийн хүүгийн орлого болон зээлийн төлбөрийн авлагаар 56,8 сая, бүгд 557,6 сая төгрөгийн орлого бүрдүүлэн 530,4 сая төгрөгийн зарлагын санхүүжүүлсэн байна.

Харин тусгай зориулалтын шилжүүлгийн 4 байгууллагууд 1344,8 сая төгрөгийн санхүүжилтийн төсөв батлуулж 1314,4 сая төгрөгийн төсвийн санхүүжилт, өөрийн орлого бүрдүүлж санхүүжилтийг 29,1 сая төгрөгийн санхүүжилт дутуу, өөрийн орлогыг 1,3 сая төгрөгөөр дутуу биелүүлжээ.

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Төсвийн Ерөнхийлөн захирагчийн багцаас сумын төрийн санд олгож Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.

Харин сум хөгжүүлэх санд 57,3 сая төгрөгийн орлого бүрдүүлж 52,4 сая төгрөгийн зээл, бусад зардлыг санхүүжүүлсэн бол, ОНХС-гийн санхүүжилтээр 91,0 сая төгрөгийн орлого бүрдүүлж 91,0 сая төгрөгийн зардал санхүүжүүлжээ.

Сумын нийт дүнгээр тайлант оны мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 52,7 сая төгрөг байсан бол оны эцэст 16,1 сая төгрөг болжээ.

Орлогыг нэр төрлөөр нь авч үзвэл байгалийн нөөц ашигласны төлбөрөөс бусад нэр төрлийн орлого тасарсан байгаагаас үзэхэд татварын орлогын гүйцэтгэл хангалтгүй байна.

Үзүүлэлт	төлөвлөгөө	гүйцэтгэл	Зөрүү
Нийт орлого	31,182,500.0	21,277,150.0	9,905,350.0
Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан	12,500,000.0	7,160,370.0	5,339,630.0
Орлогыг тодорхойлох боломжгүй	900,000.0	237,000.0	663,000.0
Хувиараа аж ахуй эрхэлсний	6,500,000.0	6,422,780.0	77,220.0
Бууны	240,000.0	240,000.0	-
Тэмдэгтийн хураамж	2,000,000.0	1,957,830.0	42,170.0
Ой нөөц ашигласаны төлбөр	700,000.0		700,000.0
Хог хаядлын үйлчилгээний хураамж	2,500,000.0	135,000.0	2,365,000.0
Байгалийн ургамал ашигласны	600,000.0	601,895.0	(1,895.0)
Түгээмэл тархацтай ашигт малтмал	2,800,000.0	900,000.0	1,900,000.0
Төсөвт байгууллагын орлого	605,000.0	300,000.0	305,000
Хүү торгуулийн орлого			-
Урьд оны үлдэгдэлээс	1,837,500.0	3,322,275.0	(1,484,775)
Дээд шатны төсвөөс авах санхүүгийн дэмжлэг	423,942,700.0	414,942,500.0	9,000,200

Сумын ИТХ-ын хуралдааны 2009 онд тогтоосон тарифаар айл өрхөөс татвар авч байгаа боловч тус тогтоолыг өнөөгийн жишиг үнэ, эрэлтэд нийцэхгүй байна.

Харин газрын төлбөрийн орлогыг сумын ИТХ-ын хуралдааны 2009 оны 07 сарын 04-ны өдрийн 03/04 тоот тогтоолны дагуу сумын иргэн аж ахуйн нэгж, байгууллагын эзэмшил, ашиглалтанд байгаа газарт газрын суурь үнэлгээ 8.0 сая төгрөгний 0.3%- 1 % хүртэл тогтоосон байна.

Иймд хууль, журамд нийцүүлэн өөрчлөлт оруулж газрын төлбөрийн орлогыг нэмэгдүүлэх талаар анхааран ажиллах шаардлагатай байна.

Орон нутгийн орлогын бүрдүүлэлтэнд тавих хяналт сулаас татварын орлого тасарч байгаад дүгнэлт хийж сумын ИТХ-аар орлогыг нэмэгдүүлэх тогтоолуудыг батлуулж мөрдөх шаардлагатай байна.

БҮЛЭГ 2. ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН, ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТЫН ТАЛААР

Сумын дүнгээрээ төсвийн санхүүжилтийг баталсан дүнгээс 84,5 сая төгрөгөөр дутуу авч, өөрийн орлогыг 1,9 сая төгрөгөөр тасалжээ.

Тус сумын төсөвт байгууллагууд 2015 онд Засгийн газар, аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын мөрийн хөтөлбөр болон бусад агентлаг, хэлтэс, сумын баг, албан байгууллагуудтай уялдуулан жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан биелэлтийг сар, улирал бүрээр тооцож ажилласан байна.

Сумын нийт дүнгээрээ 1817,1 сая төгрөгийн төсвийн санхүүжилт, 6,6 сая төгрөгийн өөрийн орлого бүрдүүлэхээр батлуулж төсвийн санхүүжилтээр 1732,6 сая төгрөгийн санхүүжилт авч, санхүүжилт авч 4,7 сая төгрөгийн өөрийн орлого бүрдүүлжээ.

2015 он Байгууллагын нэр	Баталсан төсөв/ сая.төг/ өөрийн			Гүйцэтгэл/ сая.төг/ өөрийн			Зөрүү / сая.төг/ өөрийн		
	Төсөв	орлого	Дүн	Төсөв	орлого	Дүн	Төсөв	орлого	Дүн
Хо. Дөргөн ИТХ	43.3		43.3	42.8	0	42.8	0.5	0.0	0.5
Хо. Дөргөн ЗДТГ	308.0	0.6	308.6	307.8	0	307.8	0.2	0.6	0.2
Хо.Дөргөн ОНХС	127.0		127.0	72.3	0	72.3	54.7	0.0	54.7
Хо. Дөргөн ЕБС	759.8	0.3	760.1	738.1	0.2	738.3	21.7	0.1	21.5
Хо. Дөргөн СЕБ	290.2		290.2	285.9	0	285.9	4.3	0.0	4.3
Хо. Дөргөн Соёлын төв	51.9	5.0	56.9	50.2	4.5	54.7	1.7	0.5	-2.8
Хо. Дөргөн Эрүүл мэндийн төв	236.9	0.7	237.6	235.50	0	235.5	1.4	0.7	1.4
Нийт	1,817.1	6.6	1,823.7	1,732.6	4.7	1,737.3	84.5	1.9	79.8

2.1. Сумын ИТХ-ын үйл ажиллагааны талаар:

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг чадварлаг, нээлттэй, ил тод болгон төлөвшүүлж, хөгжлийн шинэ түвшинд хүргэн иргэн, иргэний нийгмийн байгууллагын оролцоонд тулгуурлан, орон нутгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн асуудлыг бие даан шийдвэрлэх тасралтгүй үйл ажиллагаатай, хууль эрхзүйн орчныг бүрдүүлэн сумын ард иргэдийн аж амьдралыг дээшлүүлж ая тух ажиллаж, амьдрах нөхцөл бүрдүүлэх зорилго дэвшүүлэн стратеги төлөвлөгөөг дэвшүүлсэн ажиллаж байна. Зорилгодоо хүрэхийн тулд сум, орон нутагт хэрэгцээ шаардлагатай бодлогын баримт бичиг боловсруулж сумын ИТХ-ын хуралдаанаар батлуулан мөрдөж байна.

2015 онд ИТХ-ын хуралдааныг 2 удаа хийж хийж дэвшүүлсэн ханган биелүүлж, тэргүүлэгчдийн хуралдааныг 18 удаа хийж ИТХТ-ын 47 тогтоол гарсан байна. Сумын ИТХ-ын нарийн бичгийн дарга, Сумын Хурлын даргатайгаа бүтээгдэхүүн нийлүүлэлтийн гэрээ байгуулан ажилласан байна.

Сумын ИТХ-аар төрийн албан хаагчдын ажлын тайланг авч хэлэлцсэн, санхүүгийн алба, сум хөгжүүлэх сангийн зээлийн зарцуулалтанд хяналт хийж ажилласан байна.

Аудитаар ИТХ-аас сумын орлогын бүрдүүлэлт болон орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалтанд тавих хяналтыг сайжруулах зөвлөмж өглөө.

Аудитаар ИТХ-ын ажилчдын амралт томилолт илүү олгосон, зах зээлийн үнээс өндөр үнээр бичиг хэргийн материал худалдан авсантай холбоотой 57,4 мянган төгрөгийн төлбөрийн акт бичлээ.

2.2 Сумын Засаг даргын үйл ажиллагааны талаар:

Сумын ЗДТГ нь Шинэчлэлийн газар болон аймаг, сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийг эрчимжүүлж тэргүүний сум болох зорилтыг дэвшүүлэн иргэдийнхээ амьдрах орчинг сайжруулах зорилт дэвшүүлэн ажилласан байна.

Сумын Засаг даргын 2012-2016 онд хөгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангалттай гэж дүгнэгдсэн, 2015 оны нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилт 70 хувьтай хэрэгжсэн байна.

Төрийн үйлчилгээг ард иргэд, албан байгууллагуудад ил тод шуурхай хүргэх, төр ард иргэдийн холбоог бэхжүүлэх зорилт тавин ажилласан. Нийт 18 орон тоотой ажиллахаас, гүйцэтгэлээр 18 орон тоотой үйл ажиллагаагаа явуулсан.

ЗДТГ-ын дарга нь болон ЗДТГ-ын ажилчид тайлант онд бүтээгдхүүн нийлүүлэлт үр дүнгийн гэрээ байгуулан ажиллажээ.

Тус сум нь хөдөөгийн 3, төвийн 1 бүгд 4 багтай нийт 2,9 мянган хүн амд багийн үйлчилгээг хүргэн ажиллаж байна. Багийн дарга нар тайлант онд багийн Засаг дарга нь бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээгээ байгуулан жилийн эцэст ажлаа дүгнүүлэн, тухайн жилд хийж гүйцэтгэх үйл ажиллагааны төлөвлөгөөгөө батлуулан ажилласан байна.

Сумын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагаанд сайжруулах шаардлагатай анхаарал хандуулах дараах асуудлууд байна

- ЗДТГ-ын сул орон тооны захиалгыг аймгийн төрийн албаны зөвлөлд хуулийн хугацаанд нь хүргүүлж 3 ажлын байр зарласан ба төрийн албаны мэргэшлийн шалгалтанд 7 хүн орж 1 хүн тэнцсэн . 2015 онд Засаг даргын тамгын газрын сул орон тооны захиалгыг аймгийн төрийн албаны зөвлөлд хуулийн хугацаанд нь хүргүүлж ажилласан ч тамгын газрын албан хаагчдын тогтвор сууршилтай ажиллахгүй байна. Нөгөөтэйгээр сумдын засаг даргын тамгын газартай харьцуулахад бүтэц оронтоонд ихээхэн өөрчлөлттэй байна. Тухайлбал: Санхүүгийн албаны даргыг ажилуулаагүй, төрийн сангийн төлөөлөгчдөд хариуцуулан ажиллуулсан, статистикийн мэргэжилтэн төрийн сангаас тусдаа албан тушаалтан хариуцдаг, хууль эрх зүй дотоод ажил хариуцсан ажилтантай зэрэг тогтмолжоогүй орон тоонууд байна.
- Сумын Засаг даргын тамгын газрын 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 6,2 сая өртэй байсан бол 2015 онд 6,2 сая төгрөгийн өр төлбөртэй гарч 0,2 сая төгрөгөөр өр барагдуулж үлдэх төлбөр нь 2011 онд бичигдсэн малжуулах сангийн ноосны урамшуулалтай холбоотой өр байгаа тул хугацаа хэтэрсэн өрийн асуудлыг холбогдох байгууллагад хандан шийдвэрлүүлэх шаардлагатай байна.
- 2015 оны эхэнд хувь хүнээс авах авлага 2,2 сая, байгууллагаас 3,8 сая, бүгд 6,0 сая төгрөгийн авлагатай байсан бол эцэст хувь хүнээс 5,6 сая, байгууллагаас 3,8 сая төгрөг, бүгд 9,4 сая төгрөгийн авлагатай болж авлага 3,3 сая төгрөгөөр өссөн байна.

- Тайланд онд тамгын газрын 13 ажилтанд 1-5 удаа цалингийн урьдчилгаа авч нийтдээ 14,2 сая төгрөгийн урьдчилгаа цалин олгож 10,8 төгрөгийн урьдчилгаа төлбөрийг суутгаж оны эцэст 3,4 сая төгрөгийн авлагатай байна. Авлагыг ангилбал: Бадамгараваас 1200,0 мянга, Чагнаадоржоос 350,0 мянга, Нямаас 200,0 мянга, Майдуламаас 1020,0 мянга, Оюундэлгэрээс 600,0 мянган төгрөг бүгд 3370,0 мянган төгрөгийн авлагыг тайланд онд суутгаж аваагүй нь Төсвийн тухай хуулийн өглөг, авлага үүсгэхгүй байх, төсвийг үр ашигтай зарцуулах зарчмыг бүрэн хэрэгжүүлээгүй байна.
- Тамгын газрын ажилтанууд 4 албан хаагчийн 1328,4 мянган төгрөгийн холбооны зардлыг төлж цалингаас Цэдэн-ишээс 90,9 мянга, Бадамгараваас 103,4 мянган төгрөгийг суутгаж үлдэх 1134,0 мянган төгрөгийн төлбөр төлсөн байна. Сумын ИТХ-ын тогтоолоор сумын засаг дарга, тамгын газрын дарга, санхүүгийн албанд холбооны төлбөр төлөх лимит тогтоожээ. Цаашид хамт олны хурлаар хэлэлцэн холбооны лимит тогтоон, утсан холбоо тогтмол ашиглаж ажил үүргээ гүйцэтгэдэг албан хаагчдад холбооны зардал олгож байхыг зөвлөлөө.
- Ажилчдын цалингийн картанд гарын үсэг зуруулаагүй, цалингийн карт хөтлөөгүй байна. Мөн ажилчдад амралт олгохдоо ээлжийн амралт олгох тушаал гаргаж олгож байгаа нь ээлжийн амралт олгох журамтай нийцэхгүй байна. Оны эхэнд ээлжийн амралтын хуваарь тушаалаар баталж амрах үед амралтын хуудсаар баталгаажуулж байхыг зөвлөлөө.
- 2015 оны 3 сарын 15-ны өдөр тус суманд Дун гоулд ХХК-наас байгаль орчины нөхөн сэргээлтийн барьцаа төлбөрт 1,8 сая төгрөг байршуулж тамгын газрын нэмэлт дансанд тушаасан байна. Тус төлбөрийг нөхөн сэргээлт хийж ажлын гүйцэтгэлийг 100 хувь хүлээж авсны дараа өгөх барьцаа төлбөр атал сумын ой зохион байгуулах бэлтгэл ажлын зардыг санхүүжүүлсэн байна.
- Тайланд онд 1 тн нүүрсийг 78900 төгрөгөөр бүгд 79 тн, 3 тн нүүрсийг 58800 төгрөгөөр худалдан авсан байгаагаас үзэхэд нүүрсний нийлүүлэлтийн үнэ харьцангуй зөрүүтэй байна. Иймд 2015 оны 10 сард урьчдиглан 50 тн нүүрсийг 78900 төгрөгөөр авч хөрөнгийн үр өгөөжийг бууруулсан тул 1005,0 мянган төгрөгийн албан шаардлага бичлээ.
- Засаг даргын захирамжаар гаргаж буй зарим зардлын тушаалаар зарцуулсан зарцуулалтын анхан шатны баримт дутуу байна.
- “Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж үйлчилгээг зорилтот бүлэгт шуурхай, хүнд сурталгүй, чанартай хүргэх, халамж асрамжийн шинэ үйлчилгээ, менежментийг нэвтрүүлэх, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоотойгоор үйлчилгээг чанартайхүргэх” гэсэн зорилтын хүрээнд 2015 онд сумын Амьжиргаа дэмжих зөвлөл нь 19 удаа хуралдаж 66 өргөдөл хүлээн авч шийдвэрлэсэн байна. Нийгмийн халамжийн тэтгэвэр тэтгэмж, нөхцөлт мөнгөн тэтгэмж, жирэмсэн амаржсны тэтгэмж, алдарт эхийн одон, ахмад настан болон ХБИ- д эмчилгээнд явж ирсний замын зардал, рашаан сувилалын зардал, түлшний үнийн хөнгөлөлтөд 539 иргэнд 224,5 сая төгрөгийг олгожээ. Хүнс тэжээлд олгох бэлтгэн нийлүүлэгч компанийг харьцуулалтын аргаар сонгон “Дөргөн өнгөт уул” ЗБН шалгарч

гэрээ байгуулан хүнсний эрхийн бичгээр 2015 онд 18 өрхийн 135 иргэнд 14,6 сая төгрөгний хүнсний талон олгосон байна.

Аудитаар анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй 6 иргэнд 809,3 мянган төгрөгний зөрчил илэрснийг залруулах зөвлөмж өглөө.

- Сумын санхүүгийн албаны 2 нягтлан бодогчийн цалинг тамгын газрын даргын тушаалаар ТҮ-7-1, ТҮ-7-2 шатлалаар цалинжуулах тушаал гаргасан боловч ТҮ-7-5 дахь шатлалаар цалинжуулсан, Сумын төрийн сангийн төлөөлөгчийн цалинг ТҮ-8-1 дэхь шатлалаар тушаал гаргаж 2015 оны 9 сар хүртэл цалинжуулсан,

Орон нутгийн хөрөнгө оруулалт, өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалтанд тавих хяналт сул байна.

- Мөн тус сумын хөрөнгийн бүртгэлд бүртгэгдсэн халуун усны барилга, худгийн барилгыг ямар нэгэн гэрээгүйгээр хувь хүнд эзэмшүүлж байна. Халуун усанд том хүн 2000, хүүхэд 1000 төгрөгөөр үйлчлүүлж байна.
- 2016 оны 7 сараас УИХ-ын гишүүний хөрөнгө оруулалтаар ус цэвэршүүлэх төхөөрөмжийн хөрөнгө оруулалт хийгдэж 1 л усыг 5 төгрөгөөр иргэд худалдан авч борлуулж байна. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 50,0 сая төгрөгийн машин ирж гэрээ хийн ашиглаж байгаа ч гэрээнд заасан орон нутгийн өөрийн орлогыг бүрдүүлээгүй тул 2015 оны 120,0 мянган төгрөгийн төлбөрийн акт бичлээ.
- Хөрөнгө оруулалтаар 19,5 сая төгрөгийн хог тээврийн техник хэрэгсэл иргэн Д.Сүхбаатар ашиглаж байгаа ч гэрээнд заасан сард төлөх 10,0 мянган төгрөгийг төлөөгүй тул 120,0 мянган төгрөгийн төлбөрийн акт бичлээ.
- Тус байгууллагын хөрөнгийн бүртгэлд нэг бүр нь 180,0 мянган төгрөгийн өртөг бүхий 2 морь байгаа ч хорогдсон ч хасат хийж шийдвэр гаргуулаагүй, 2006 онд ашиглалтанд орсон 2,4 сая төгрөгийн өртөг бүхий трактор байгаа ч ашиглах боломжгүй болсон байна.

Аудитаар 5620293 төгрөгийн зөрчил илэрснээс 2840293 төгрөгийн төлбөрийн акт 2780000 мянган төгрөгийн алдааг залруулах албан шаардлага бичлээ.

2.3 Сумын байгуулагдсаны түүхт 60 жилийн ойн хөрөнгийн бүрдүүлэлтийн талаар:

Сумын ИТХ-ын 2015 оны 6 дугаар сарын 29-ний 9/07 тоот тогтоолоор сумын түүхт 60 жилийн ойг угтан хийх 60 бүтээлч ажлын төлөвлөгөө гарган батлан ажилласан байна. ИТХ-ын тогтоолоор “Таван хошуу малын баяр”, сумын түүхт 60 жилийн ойг тэмдэглэх өдрийг товлон, сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсгийг бөх, морь, сур, хэв журам сахиулах, аж ахуйн болон таван хошуу малын баярыг тэмдэглэх комиссыг томилон зохион байгуулжээ.

Аудитын хугацаанд ирүүлсэн анхан шатны баримтаас үзэхэд сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансаар 2015, 2016 оны 8 дугаар сарын 4-ний өдрийг хүртэлх хугацаанд сумын төсөвт байгууллагуудаас 12,4 сая, багуудын малчдаас өгсөн малын хандивын орлого 24,1 сая, малын арьсны үнэ 0,8 сая, УБ, Дархан,Эрдэнэт хот болон бусад газруудад амьдарч байгаа нутгийн иргэд хөдөлмөрчдөөс 41,0 сая, бэлнээр ойн хүлээн авалтанд 2,1 сая, ОНХСангаас 5,0 сая **бүгд 85,5 сая** төгрөгний орлого бүрдүүлжээ.

Бүтээн байгуулалтаар иргэн Б.Цэрэнгийн үр хүүхдүүд 24,0 сая төгрөний дурсгалын чулуун багана, Цогбадрах ЗДТГ-ын өмнөх талбай тохижуулахад 13,0 сая, Төрмөнхийн үр хүүхдүүд ЗДТГ-ын урдах соёмбоны чулуун хөшөө 10,0 сая, Дөргөний УЦС-д ажиллаж байгаа нутгийн иргэд хурдан морины хашаа 2,0 сая бүгд **49,0** сая төгрөний хөрөнгө бэлтгэсэн байна. Сумын 4 багуудын малчдаас тэмээ 2, адуу 2, үхэр 3, хонь 58, ямаа 174 нийт 239 толгой мал хандивлаж үүнээс 143 толгой малыг зарцуулж үлдэгдэл 96 малыг Сээр багийн малчин М.Баатар Аюушид комисс томилон хүлээлгэн өгсөн байна.

Аудитад ирүүлсэн санхүүгийн баримт, холбогдох баримтаас үзэхэд сумын ойг тэмдэглэн өнгөрүүлсэн комиссууд нь ажлын тайлан бичээгүй, багуудын малчдаас хандиваар өгсөн малыг төсөвт байгууллагуудын хүсний хэрэгцээнд өгсөн тооцоог байгууллага бүрээр нарийн тооцоогүй, ойн арга хэмжээний нэгдсэн тооцоог бүрэн бодоогүй байгаа дутагдал байна.

Тус ойн хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тайланг нэгтгэн эцэслэж гаргаагүйгээс ямар байгууллагад хичнээн хэмжээний өр, хэнээс хэдэн төгрөгийн хандивын авлага авах нэгдсэн тооцоо гаргаагүй байна.

Сумын түүхт 60 жилийн арга хэмжээний орлогыг нутгийн иргэд, ААН-ээс бүрдүүлж зарцуулсан боловч иргэдэд ойн тайланг нэгтгэн гаргаж танилцуулаагүй байгаа тул бүх багуудын хурлаар танилцуулан хэлэлцүүлж ойн тайланг иргэдэд ил тод мэдээлэл хүргүүлэх шаардлагатай байна.

Иймд 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг гаргахаар өмнө төсвийн байгууллагууд хийгдсэн хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтын ажлуудыг орлого авч бүрэн бүртгэх, 60 жилийн ойн нэгтгэл тайланг гаргаж дахин хянуулах зөвлөмжийг сумын удирдлагууд болон нягтлан бодогч нарт хариуцууллаа.

2.3 Сум хөгжүүлэх сангийн талаар

Сум хөгжүүлэх санд 2011 оноос хойш 265,0 сая төгрөгийн зээлийн эх үүсвэр бүрдэж 2015 оныг хүртэл 47 иргэнд 364,3 сая төгрөгийн зээл олгожээ. Харин 2015 онд 8 иргэнд 78,6 сая төгрөгийн зээл олгожээ.

Зээл авсан иргэд гэрээнд заасан хугацаанд зээлийн төлбөрийг төлөөгүй, зориулалт бусаар зээлийг ашигласантай холбоотой 18 иргэнийг эвлэрүүлэн зуучлуулагчид өгч зээлийн төлбөрийг барагдуулж байгаа ч одоог хүртэл зээл, зээлийн хүүгийн төлбөр хугацаа хэтэрч сангийн хөрөнгийн эргэлтийг бууруулсаар байна.

Тус сангийн мөнгөн хөрөнгийн 2015 оны эхний үлдэгдэл 49,0 сая төгрөг байсан бөгөөд тайланд онд зээл, зээлийн хүүгийн төлбөрөөс 44,4 сая төгрөгийн орлого бүрдүүлж 78,6 сая төгрөгийн зээл олгож, 2,0 сая төгрөгийн лангууны үнэ төлж оны эцэст 12,8 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

2015 онд тус сангаас хяналтын зардал санхүүжүүлээгүй бөгөөд сум хөгжүүлэн сангийн журмын 1.8-д "Сангаас олгох зээлийн хүүгийн тухайн жилийн орлогын 30 хувийг зээлдэгчдэд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтад, 20 хувийг сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төслийн явц, үр дүнд хяналт тавих үйл ажиллагаанд зориулан зарцуулна" гэж заасан байгааг цаашид хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

Сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан сум хөгжүүлэх сангийн зээл олгох зөвлөлд 2015 онд зээл авах хүсэлтийг 12 иргэн ирүүлж 3 иргэнд олгосон, 2015 онд 18 иргэн ирүүлсэнээс 8 иргэнд зээл олгосон байна.

2015 онд олгосон зээлийн хэрэгжилтийг хянахад иргэн Г.Ундрахын тарианы гурил үйлдвэрлэл, Б.Рагчаадоржийн мотоцикль засварын төслүүд байна. Иргэн М.Батжаргалын зөөлөн оёдол, Мөнхжаргалын халуун ус, Я.Лхамсүрэнгийн тараг үйлдвэрлэлийн төслүүд нь үйл ажиллагаа нь тогтмолжоогүй ч бага хэмжээний үйл ажиллагаа явуулж байна.

Харин Д.Гантулгын ингэний хоормог үйлдвэрлэлийн 14,0 сая төгрөгийн зээл үйл ажиллагаагаа зориулалтын дагуу явуулж суманд ЖДҮ эрхлээгүй байна.

Мөн иргэн Ц.Бадамхандад эмийн эргэлтийн сангийн үйл ажиллагааг өргөтгөхөд зориулж 25,0 сая төгрөгийн зээл баталж 2015 онд 19,4 сая төгрөг, 2016 онд үлдэх 5,6 сая төгрөгийг олгосон нь жижиг дунд үйлдвэрлэл бус сумын иргэдэд эм борлуулж ашиг олдог худалдааны чиглэлийн төсөлд зориулалт бусаар олгожээ.

Энэ нь 2016 оны 3 сарын 14-ны өдрийн 153 тоот Засгийн газрын тогтоолын СХС-гийн журмын холбогдох заалтуудтай нийцэхгүй байна.

Иймд иргэн Д.Гантулгын ингэний хоормог үйлдвэрлэл 14,0 сая төгрөг, иргэн Ц.Бадамхандын эмийн сангийн үйлчилгээний 19,4 сая, бүгд 39,0 сая төгрөгийн зээлийг буцаан төлүүлж бусад зээл авах жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч нарт зээл олгох акт бичлээ.

Дээрх байдлаас үзэхэд сум хөгжүүлэх зээлийн эх үүсвэр 265,0 сая төгрөгөөр бүрдэж орон нутагт жижиг дунд үйлдвэрлэл хөгжүүлэх нөөц байгаа хэдий ч өмнөх зээл авсан иргэд төлбөрөө төлөөгүйтэй холбоотой олгогдсон зээлийн тоо, зээлийн эргэц хангалтгүй байна.

2.4 Орон нутгийн Хөгжлийн сангийн талаар:

2015 онд ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар нийт 17 ажил хийхээр төлөвлөсөн бөгөөд 4 ажлыг харьцуулалтын аргаар, олон нийтийн оролцооны аргаар 1, үлдсэн 12 ажлыг шууд гэрээ байгуулжээ. Сумын ИТХ-ын хуралдаанаар 01/02 тоот тогтоолоор анх 209,0 сая төгрөгийн санхүүжилт баталж улмаар санхүүжилт танагдсантай холбоотой тодотгол хийгдэн 127,0 сая төгрөгөөр баталж гүйцэтгэлээр 72,3 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг авч зарцуулжээ. Аймгийн ОНХС-гаас 30,0 сая төгрөгийн санхүүжилт авч сумын соёлын төвийн засварын ажлыг хэрэгжүүлсэн байна. Нийт ажлын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

№	Төсөл арга хэмжээний нэр хүчин чадал байршил	2015 оны тодотгосон төсөв	12 сарын 30 - ны Гүй	Ажлын тайлан
1	Сумын ерөнхий төлөвлөгөө 2013 оны дутуу санхүүжилт	22940.0	22940.0	ШУА - аар сумын ерөнхий төлөвлөгөө хийлгүүлж 2015 онд хүлээн авсан.
2	Жишиг багийн төв	1882.5	1882.5	Төндэрийг Алтайн тайж ХХК авч ажлыг гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Үлдэгдэл санхүүжилтийг 2015 онд шилжүүлсэн.
3	Гэрэлтүүлэг	2566.4	2566.4	Төндэрийг Топ металл ХХК авч ажлыг гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Үлдэгдэл санхүүжилтийг 2015 онд шилжүүлсэн.
4	Наадмын талбай шинэчлэх	2000.0	2000.0	Үлд санхүүжилт шилжүүлэв.
5	Төв талбай	12600.1	12534.0	Төндэрийг Алтайн тайж ХХК авч ажлыг гүйцэтгэн хүлээлгэн өгсөн. Үлдэгдэл санхүүжилтийг 2015 онд шилжүүлсэн.
6	Төв гудамжны гэрэлтүүлэг	0.0	0.0	
7	Ногоон байгууламж	0.0	0.0	
8	Эмийн эргэлтийн сангийн байрны засвар	5000.0	5000.0	Шууд гэрээгээр Р.Очируянга авч гүйцэтгэсэн. Засварын ажлыг зомисс хүлээн авч санхүүжилтийг олгосон.
9	Сумын иргэдийн төлөөлөгчдийг чадавхижуулах хөтөлбөр	10000.0	5260.0	Сумын ИТХ ажлын алба төлөөлөгчид Хөвсгөл аймгийн тосонцэнгэл сумтай туршалаг солилцож мөн НУхолбооны сургалтанд хамрагдаж улаан үүд явж ирсэн.
10	Цэвэр гудамж , цэмцгэр сум хөтөлбөр	40000.0	0.0	Санхүүжилт хүлээгдэж байна.
11	Малын чанар сайжруулах дэд хөтөлбөр	10000.0	2129.0	Сумын бэлчээрийн менежментийн холбоо, МЭҮТ 3 сан гэрээгээр баяд омгийн хуц авч ирсэн. Мөн сээр багийн дарга С.Нямхүү ахлагчтай хүмүүс Говь - Алтай аймагт тэмээчлийн зөвлөгөөнд оролцсон .
12	Тэмээ өсгөх дэд хөтөлбөр	5500.0	5500.0	Боттоны урамшуулал олгосон.
13	Малжуулах хөтөлбөр	0.0	0.0	
14	Иргэдийн санаачилгад тулгуурласан бүтээлч ажлын сан	2371.1	2250.0	Сургуулийн дотуур байрны тохижилтонд зориулж 225,0 төгрөгөөр шүүр хогийн сав авч өгсөн, Авъяас хөтөлбөрийн хүрээнд ЕБС дээр зохион байгуулагдаж байгаа тэмцээний шагналд 600,0 , Нуурын хогны хашилт 675,0 төгрөг
15	Энгийн гар уурхайн худаг гаргахад дэмжлэг үзүүлэх	5000.0	3500.0	Засаг даргын зөвлөлөөр хэлэлцэн шаардлагатай засварлах худгийг сэргээн засварласан.
16	Аварга хөтөлбөр үндэсний нум сум	2140.0	1750.0	Монгол бөхийн өргөөнөөс нум сум худалдан авсан.
17	Улсын баяр наадам	5000.0	5000.0	Баяр наадмаа тэмдэглэн өнгөрүүлсэн.
ДҮН		127000.1	72311.9	

Аудитын явцад хэрэгжүүлсэн ажлын гүйцэтгэлийг хянахад ОНХС-гийн санхүүжилтээр сум орон нутгийн хөрөнгө оруулалтыг дэмжсэн бодит хэрэгцээт ажлууд хэрэгжүүлж ажилласан байна. Тухайлбал: Энгийн гар худаг гаргах, тэмээ өсгөх дэд хөтөлбөр, жижиг багийн төвийн ажлууд байна.

Харин 2015 оны төсөвт нутгийн өөрөө удирдах байгууллагын чадавхижуулах хөтөлбөрт 10,0 сая төгрөг баталж 5,2 сая төгрөгийн зардлыг төлөөлөгч нарыг туршлага судлуулах ажилд зарцуулжээ. Мөн сумын иргэдэд үйлчилгээ үзүүлж аж ахуйн тооцоон дээр ашиг олон ажилладаг сумын эмийн эргэлтийн сангийн засварын ажилд 5,0 сая төгрөг олгосон байна.

Дээрх 2 ажлыг иргэдээс санал авч эрэмбэлсэн байдлаар батлуулаагүй байна. Гэтэл нийт иргэдийн саналаар илүү санал авсан орон нутагт хийгдэх хэрэгцээт хогийн цэг байгуулах, малжуулах хөтөлбөр, ундны ус зэрэг ажлууд тус онд хийгдээгүй байна.

Энэ нь Сангийн сайдын Орон нутгийн хөгжлийн сангийн 43 тоот тогтоолын 4.2 дахь "Тухайн орон нутгийн иргэдийн саналыг авч зохих журмын дагуу

эрэмбэлэгдээгүй байх”, 4.4 дэхь “Аймаг, нийслэл, сум дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх”, 4.6 дахь “ОНХС-гийн хөрөнгийг буцалтгүй тусламж дэмжлэгт зарцуулахгүй байх” зэрэг заалтыг зөрчсөн тул цаашид тус ажлыг санхүүжүүлэхгүй байх зөвлөмж өглөө.

Өмнө орнуудад хийгдсэн ОНХС-гийн зарим хөрөнгө оруулалтын ажлууд хангалтгүй байна.

2014 оны ОНХС-гийн хөрөнгө оруулалтаар 40,0 сая төгрөгийн өртөг бүхий жишиг хашаа хөтөлбөрийг хэрэгжүүлж 28,0 сая төгрөгийг олгожээ. Тус ажлын хүрээнд 2 гудамжны айлуудын хашааг модон болгож нэг загварын болгосон бөгөөд хашааны үнээс 2015 онд 0,6 сая төгрөг авч үлдэх төлбөрийг авлагаар бүртгэсэн байна. Дээрх байдлаас үзэхэд уг ажлын гүйцэтгэл, ажлын үр дүн хангалтгүй байна. Мөн орон нутгийн телевиз байгуулах ажилд 5,0 сая төгрөг олгосон одоо мөн ажиллахгүй байгаагаас үзэхэд төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулсан ажил болжээ.

2016 онд сумын төвийн зам тавих ажлыг Батдайчин ХХК-тай 50,0 сая төгрөгийн гэрээ байгуулсан ч ажлын гүйцэтгэл мөн хангалтгүй байна.

2.5 Ерөнхий 12 жилийн Ерөнхий боловсролын сургуулийн талаар :

“Алдаагүй зөв, цэвэр, сайхан бичигтэй, бий биелгээг биелэдэг, цэвэрч нямбай суралцагчийг төлөвшүүлнэ” гэсэн зорилтын хүрээнд 23 бүлэгт 626 сурагч суралцаж 68 багш ажилчидтай үүнээс тэргүүлэх зэрэгтэй 11, заах арга зүйч багш 16, дотуур байранд 100-110 сурагч амьдарч сургалт хүмүүжлийн үйл ажиллагаагаа явуулсан байна.

2015 онд улсын төсвөөс 759,8, өөрийн орлогоор 0,3 **бүгд 760,1** сая төгрөгөөр батлагдаж гүйцэтгэлээр төсвөөс **740,1** сая төгрөгний санхүүжилт авч 740,1 сая төгрөгний зардал гарган, ерөнхий менежер нь 2015 онд 82 оноогоор дүгнүүлжээ.

ЭЕШ-ын дундаж оноо 476 болж өмнөх оноос 17 оноогоор, АВ-ын эзлэх хувь 45% буюу өмнөх оноос 7%-иар өссөн хэдий ч аймгийн БСГ-аас дүгнэсэн сумдын сургуулиудын 2015 оны ажлын үнэлгээгээр 19 дүгээр байранд орсон байгаагаас үзэхэд тус сумын дэвшүүлсэн зорилтын хэрэгжилт хангалтгүй байна.

Сумын сургууль нь 2015 оны хичээлийн жилд аймгийн хэмжээний мэргэжлийн хичээлийн олимпиадад 16 багш, 30 сурагч оролцож Газарзүйн багш Б.Амартүвшин улсын олимпиадад амжилттай оролцсон. Мөн сурагчдыг 3 дугаар цагийн засварлагаагаар “Хөдөлгөөнт гимнастик” хийж хэвшсэн, 1-12 ангийн бүх сурагчид “Дөрвөд” бие биелгээ бүжгийг сурчээ.

Ном авьяас хөтөлбөрийн хүрээнд 19 төрлийн сонгон секц дугуйланд давхардсан тоогоор 932 сурагч хамрагдаж, Агвааш багийн иргэн Жүгдэр, Цэндсүрэн нар ивээн тэтгэн “Номын өргөө” байгуулан сурагчид байнга үйлчлүүлж хэвшсэн байна.

ДЗОБ-тай хамтран 100 эцэг эхийн чуулга уулзалтыг зохион байгуулж, дотуур байрны сурагчдын нэгдсэн концерт тоглосон, сурагчдын эцэг эхийн өдрийг 2 удаа зохион байгуулж хүүхдүүдийн амьдрах таатай тухтай орчинг бүрдүүлэх зорилгоор өөрсдийн санаачлагаар тасгуудыг тохижуулах ажлыг дотуур байрны багштай хамтран зохион байгуулж 2014-2016 онууд Норвегийн тусламжийн “Хүүхдийн эрх хөгжил 2” гэсэн төслийг хэрэгжүүлэн “Шилдэг дотуур байр”-аар шалгарсан зэрэг олон бүтээлч ажлуудыг хийсэн байна.

Сумын сургуулийн үйл ажиллагаанд хэрэгжүүлсэн дээрх ололтой талууд байгаа хэдий ч дараах алдаа зөрчлийг засаж сайжруулах шаардлагатай байна.

- Сургуулийн дотуур байрны багш нар хүүхдийн ирц бүртгэлийг бүрэн бүртгээгүй, зарим тасгуудад хүүхдүүд ороогүй доторх хогийг цэвэрлээгүй, нүүр гар угаах өрөөнд байрлуулсан ус халаагчийг дотор монтажнаас авч олон залгуур залган хэрэглэж байгаа боловч нь хүүхдүүд нүүр гараа угааж байхад тог цахилгаанд цохиулах магадлал өндөр, галлагааны яндан 2 дугаар давхарын тасгаар дамжин гадагш гардаг тасагт хүүхдүүд байрлаж байгаа нь бага насны хүүхэд гал түлсэн үед гар, хөлөө түлэх эрсдэл өндөртэй байна.

- Дотуур байрны гал тогооны үйл ажиллагаатай танилцахад хоолны цэсийг 7 хоногоор гаргаж захирлаар батлуулаагүй, байрны хүүхдүүдэд 16 цагт цай, печень, чокофай зэрэг чихэрлэг бүтээгдэхүүн олгож байгаа нь ЭМСайд, БСШУЯ-ны сайдын 2005 оны 225/296 тоот тушаалаар баталсан норм нормативыг мөрдөөгүй, хоолны дээжийг авч хөргөгчид хадгалаагүй, устгасан тухай тэмдэглэл хөтлөөгүй

- Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилтэнд тавих хяналт сулаас жилийн эцсийн тайланд 2,0 сая төгрөгөөр өглөг илүү тусгасан, сургуулийн эмч декриттэй байх хугацаанд түр ажиллаж хугацаагаар ажиллаж байсан эмч нь 9 сараас хойш бүртгэл хөтлөөгүй, жижүүрийн бүртгэсэн бүртгэл засвартай бүрэн гүйцэт бүртгээгүй дутагдал зөрчил байна.

- Багш ажилчдаас авсан санал асуулгаар 2016 оны амралтын цалинг дахин шалгуулах гэсний дагуу тооцон үзэхэд 3854225 төгрөгийг илүү, 984457 төгрөгийг дутуу тооцон олгосныг 10 сард багтаан олгох төлбөрийн акт бичлээ.

- Зарим багш ажилчдад зэргийн нэмэгдэл болон кабинетийн нэмэгдэл илүү, үдийн цайны мөнгийг илүү шилжүүлсэн, амралтын дундажыг зөрүүтэй тооцож илүү олгосонтой холбоотой 4 хүнтэй холбоотой 664311 төгрөгний төлүүлэх төлбөрийн акт, 35 багш нарт 1253006 төгрөгний амралтын цалин дутуу бодож олгосныг буцаан олгох акт бичлээ.

- Багш ажилчдад улирлын үр дүнгийн урамшуулалыг ажлын үр дүнтэй уялдуулан олгодоггүй, сургалтын менежер болон нийгмийн ажилтанд жилийн туршад 25%-иар олгосон, багш нарт ур чадварын нэмэгдлийг олгохдоо хэт хавтгайруулан олгодог дутагдал байна.

- Байрны багшид зэргийн нэмэгдэл олгосон, өнгөт принтерийг зах зээлийн үнээс өндөр үнээр худалдан авсан, зарцуулсан шатахууны үнийг нэхэмжлэхийн дагуу төлж шууд зардалд тусгасан 7098577 төгрөгний эд хариуцагчийн тайлан гаргаагүй тул албан шаардлага бичлээ.

- Батлагдсан орон тоогоор ажиллаж байгаа ч бичиг хэргийн ажилтан, сантехникч гэсэн орон тоо батлагдаагүй байхад ажиллуулж байна. БСШУЯ-аас баталсан норм нормативиар 700-аас дээш хүүхэдтэй бол номын санч, бичиг хэргийн ажилтан тус бүр 1 ажиллахаар заасан боловч мөрдөөгүй байна.

- Тайлант оны 6 дугаар сарын 29-ний өдөр Түвшинбаярын хувийн харилцах дансруу материалын үнэ 2,0 сая төгрөгийг шилжүүлж, эд хариуцагчийн тайланд материал орлого авсныг нотлох баримт байхгүй байгаад СТА-аар төлүүлэхээр акт бичсэн гэтэл захирлын А/31, А/25 тоот тушаал нөхөн гаргаж багш ажилчдын идэвхтэй амралт, хүүхдийн баяраар хүүхдүүдэд бэлэг олгосон тушаал хавсаргасан байна. Гэтэл сумын төрийн сангийн баримтанд уг шилжүүлгийн 1 хувь хавсаргагдаагүй байна. Зарим багш ажилчдаас асууж лавлахад тийм арга хэмжээ зохион байгуулаагүй, багш ажилчид өөрсдөө мөнгөө нийлүүлж идэвхтэй амралт

зугаалга хийсэн, хүүхдийн баяраар тэмцээн уралдаан зохион байгуулаагүй, бэлэг олгоогүй байгаа нь хуурамч баримт бүрдүүлсэн нь нотлогдож байна. Мөн сумын ойг угтан багуудын малчдаас хандив өгсөн малыг сумын төсөвт байгууллагуудын хүнсний хэрэгцээнд олгож мөнгийг нь ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн боловч хандиваар ирсэн махны үнийг 10 дугаар сарын 4-ны **3795,0** мянган төгрөгийг **Оюунхүүгийн хувийн харилцах** дансанд шилжүүлсэн төлүүлэхээр төлбөрийн акт бичсэн боловч одоог хүртэл актыг барагдуулаагүй тул хууль, хяналтын байгууллагад шилжүүлж холбогдох албан тушаалтануудад арга хэмжээ авах шаардлагатай байна.

- Нягтлан бодогч нь зарим багш ажилчдаас амралтын цалинг илүү бодсон гэж мөнгийг бэлнээр авсан холбоотой маргаантай асуудал үүсэж шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж холбогдох хүмүүст нь төлбөрийг буцаан олгосон байна.

- Хичээлийн байранд цайны газар ажиллуулахаар гэрээ байгуулсан боловч гэрээний хугацаа дуусахаас өмнө гарсан, ажиллах хугацааны түрээсийн төлбөрийг дансанд төвлөрүүлээгүй нягтлан бодогч нь тооцоо бодоогүй, байранд засвар хийж төсөвт орлого төвлөрүүлээгүй байна.

- Эд хариуцагч нь сар бүр тайлан гаргаж нягтлан бодогч нь худалдан авсан болон зарцуулсан бараа материалыг нэр төрөл тоо хэмжээгээр нь нарийн тооцоог бүрэн бодоогүй санхүүгийн программд мэдээллээ оруулаагүй дутагдал байна.

Аудитаар нийт 13,705,504 төгрөгний төлбөр, зөрчил илэрснээс 4,580,841 төгрөгний төлүүлэх акт, 2,026,086 төгрөгний буцаан олгох акт, 7098577 албан шаардлага бичлээ.

2.6 Сумын цэцэрлэгийн үйл ажиллагааны талаар :

Хүүхдийн цэцэрлэг нь 2015 онд хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх зорилт дэвшүүлэн зорилтоо ханган биелүүлэхийн тулд үндсэн 7 бүлэгт 175 хүүхэдтэйгээр, хувилбарт сургалтийн 3 гэр цэцэрлэгт 255 хүүхэд хүмүүжиж, 9 багш 19 ажилтантайгаар сургуулийн өмнөх боловсрол олгох үйлчилгээг зохион байгуулан явуулжээ. Багшлах боловсон хүчний 100% -ийн мэргэжлийн зэрэгтэй багш нар хүүхдийн нас сэтгэхүйн хэрэгцээ сонирхолд нийцүүлэн ангиа тохижуулан сургалтын үйл ажиллагааг 02 насны асран хамгаалах, 3-4 насны хүүхдийг хөгжүүлэх, 5-6 насны хүүхдийг сургуульд бэлтгэх хувилбарт сургалтууд гэсэн чиглэлээр хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх тэднийг дэмжих сургалт хүмүүжлийн үйл ажиллагааг хэвийн зохион байгуулсан байна.

Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх сургалт семинарт 8, сургуулийн өмнөх боловсролын сургалтын технологийн арга зүйн шинэчлэл сургалтанд 4 багш хамрагдсан байна. Анги бүлэг бүр сургалтын хөтөлбөр боловсруулан баталгаажуулж тоглоомын аргаар хүүхдийн хэрэгцээ сонирхол сонгосон булангийн үйл ажиллагаанд тулгуурлан хөгжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан байна.

Монгол Улсын засгийн газраас хэрэгжүүлж байгаа “Ном”, “Авьяас” хөтөлбөрийн хүрээнд 2-5 насны хүүхдүүдэд ардын дууны, биелгээний, гимнастикийн төрлүүдээр хүүхдүүдийг хичээллүүлж сумандаа “Дөрвөд ардын дуу”, “Дөрвөд биелгээ”, “Хөдөлгөөнт гимнастик” зэрэг тайлан тоглолтуудыг амжилттай зохион байгуулж үйл ажиллагаагаа сурталчилж ажиллажээ.

Төсвийн ерөнхий менежер 2015 онд төсвийн ерөнхийлөн захирагчтай бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж үр дүнгийн гэрээгээ 97 хувиар ханган биелүүлэн “А” үнэлгээ авч аймгийн хэмжээнд 5-р байранд орсон байна.

Тус цэцэрлэг нь улсын төсвөөс 290,2 сая төгрөгийн санхүүжилт авах төлөвлөгөөтэйгээс гүйцэтгэлээр 285,9 сая төгрөг авч батлагдсан төсвийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулсан байна.

Шилэн дансны тухай хуулийн хүрээнд зохих мэдээллийг бүрэн оруулж байршуулсан боловч санхүүгийн мэдээлэлийн самбарыг байгууллагад тухай бүр мэдээлэлх мэдээлэлийн самбаргүй байна.

2015 онд Дэлхийн зөн ОУ-ийн байгууллагатай хамтран ажиллаж 5,1 сая төгрөгийн хүүхдийн тоглоом, ширээ сандал болон бусад хөрөнгө оруулалтын ажил хийгджээ. Эцэг эхчүүдтэй хамтран 390 ширхэг үлгэрийн зурагтай ном бүтээж сургалтанд хэрэглэхээр багш нарт гарын авлага болгон тараасан байна.

Байгууллагад дээрхи ололттой талууд байгаа нь сайшаалтай боловч цаашид анхаарч ажиллах дараах зөрчил дутагдлууд илэрч байна.

- Тушаал шийдвэртэй боловч зарим ажилчдын ур чадварын нэмэгдэл олгоогүй 389,2 мянган төгрөгийг буцаан олгох акт, амралт цалин давхардсан, үр дүнгийн нэмэгдлийг тушаалаас илүү хувиар бодож авсан 386,1 мянган төгрөгийн төлбөрийн акт бичлэ.
- Багш ажилчдад үр дүнгийн урамшуулалыг хавтгайруулан олгосон, илүү цагийн хөлсийг олгосон, цагийн тооцоо бүрэн биш, илүү цагийн бүртгэл хөтөлж баталгаажуулаагүй байгаа зөрчлийг давтахгүй байх зөвлөмж өглөө.
- Шатахууны тооцоо бодоогүй, замын хуудас бичээгүй, няравын тайлан гаргаагүй, шууд зардалд тусган шатахуун зарцуулсан байгааг анхаарч тайлан тооцоог бүрэн гаргаж ажиллах зөвлөмж өглөө.
- Хүүхдийн хоолны зарцуулалтанд тавих хяналт сул, хүүхдийн ирцийн бүртгэл хангалтгүй, анги удирдсан багшийн ирцийн бүртгэлтэй хоолны талоны хүүхдийн тоо зөрүүтэй бичигдсэн, 4,5,12-р сарын 10252 хүүхэд өдрийн буюу 16,2 сая төгрөгийн хоолны талон баримтанд хавсаргаагүй нь ня-бо, няравын ажлын хариуцлага хангалтгүй байгаад засч залруулах албан шаардлага өгч, багшийн журналын хүүхдийн ирц, талоноор зарлагдаж байгаа хүүхдийн тоо зөрүүтэй бичигдсэн тул 286 хүүхэд өдрийг илүү зарцуулсан тул 471,9 мянган төгрөгийн төлбөрийн акт бичигдэж байна.
- Нүүрсний үнийг шилжүүлээд тооцоо бодоогүй, зарцуулалтын тайлан гаргаагүй нэг дор бөөн дүнгээр зарлагдаж байгаад хяналт тавьж ажиллах, няравын складын бүртгэл хөтлөөгүй, склад, агуулах шаардлага хангахгүй, тайлан гаргалт сул байна.
- Боловсрол шинжлэх ухааны сайдын 225/296 тоот тушаалаар баталсан хүүхдийн хоногийн хоолны орц норм, үндсэн шимт бодис, илчлэгийн хэрэгцээ шаардлагын дагуу хоолны зэс гарган батлуулж баталсан зэсээр хоолыг амч чанартай бэлтгэж өгөх, гал тогооны тоног төхөөрөмжийг сайжруулах шаардлагатай байна. Аудитын хугацаанд баталсан цэцэрлэгийн эрхлэгчийн хоолны цэсийг хянахад гоймон, варень, печень зэрэг бэлэн бүтээгдэхүүн түгээмэл хэрэглэж байгаагаас үзэхэд хүүхдийн хоолны бараа

материалын нийлүүлэлтэнд тавих хяналт сул, тогооч нарын ажлыг сайжруулах шаардлагатай байна.

- Санхүүгийн программыг бүрэн ашиглаагүй санхүүгийн тайлан болон бараа материал, цалинг программаар гаргаж хэвшээгүй байна.

Гүйцэтгэлийн аудитаар ур чадварын нэмэгдлийг олгоогүй, амралт цалин давхардуулан олгосон, хүүхдийн журналын ирцийн тоо талоноор зарлагдаж байгаа хүүхдийн тоотой зөрсөн зэрэгтэй холбоотой 1,2 сая төгрөгийн төлбөрийн акт, хүүхдийн хоолны талон дутуу хавсаргасан, шатахууны тооцоо бодоогүй, няравын тайлан заавар журмын дагуу гаргаагүй, 22,9 сая төгрөгийн албан шаардлага бичлээ.

2.7 Сумын эрүүл мэндийн төвийн үйл ажиллагааны талаар:

Тус эмнэлэг нь 2015 онд 23 орон тоотойгоор “Ард иргэдэд эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг чанар хүртээмжтэй хүргэх” гэсэн зорилт дэвшүүлж, сумын эмнэлгийн стандартыг хангах гэсэн зорилт тавин ажиллажээ.

Тавьсан зорилтоо хэрэгжүүлэхийн тулд 2015 онд давхардсан тоогоор 9510 хүнд амбулаторийн үзлэг хийж, 2128 ор хоног ашиглаж, 332 хүн хэвтэн эмчлүүлж, багаас ирсэн 231 дуудлаганд явж үйлчилгээ үзүүлсэн, ажилчин нэг бүртэй үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээ хийж жилийн эцэст дүгнэн, төсвийн захирагч Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчтай бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ байгуулж ажилласан ч оны эцэст үр дүнгийн гэрээгээ дүгнүүлээгүй байна. Нийгмийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр нийт 14 хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагаа явуулсан байна

2015 онд эмнэлгийн үйл ажиллагааны зардалд улсын төсвөөс 237,2 сая төгрөгөөр, үндсэн үйл ажиллагааны орлогоос 0,4 бүгд 237,6 сая төгрөгөөр батлагдаж гүйцэтгэлээр улсын төсвөөс 235,5 сая төгрөгний санхүүжилт авч анхан шатны тусламж үйлчилгээ, нийгмийн эрүүл мэндийг дэмжих чиглэлээр үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Илрүүлэлт:

- Тус эмнэлэгт хөрөнгө оруулалтаар ирсэн биохимийн анализатор байгаа боловч ашиглалтгүй, тус шинжилгээг хийх боловсон хүчнийг сургаж авсан ч оношлуурын бодисны үнийг эмийн зардлаас санхүүжүүлээгүйтэй холбоотой тус хөрөнгө ашиглалтгүй хадгалагдаж байна. Зарим сумдын эрүүл мэндийн төвүүд сумын ИТХ-аар оношилгооны эмийн бодисын үнийг худалдан авах өртөгийг нэг иргэнээр тооцон батлуулж орлогоороо зардлаа нөхөн сумандаа чирэгдэлгүйгээр төрөл бүрийн шинжилгээ авч байгаа туршлагыг нэвтрүүлэх шаардлагатай байна.
- Ажилчдад цалин олгохдоо зөрүүтэй тооцож илүү олгосонтой холбоотой 97796 төгрөгний төлбөрийн акт бичигдлээ.
- НЭМАжилтанд Засгийн газрын 90 тогтоолын нэмэгдэл олгосон 524691 төгрөгт төлбөрийн албан шаардлага бичлээ.
- Холбогдох байгууллагатай шатахууны тооцоо нийлээгүй, 10, 11 сард жолоочийн тооцоо бодоогүйтэй холбоотой **1404880 төгрөгийн зөрчил илэрлээ.**
- Тендерийн эмийн тооцоог эм нийлүүлэгч байгууллагуудтай тооцоо нийлээгүйтэй орлогын баримтыг тухай бүр тооцоогүйтэй холбоотой 901959 төгрөгийн зөрчлийг арилгуулах албан шаардлага бичлээ.

- Мөн шатахууны болон эмийн үнийг зөрүүтэй тооцсонтой холбоотой 82700 төгрөгийг илүү шилжүүлсэнд төлбөрийн акт бичигдлээ

Гүйцэтгэлийн аудитаар 180496 төгрөгийн төлбөрийн акт, 2831530 төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага бичигдлээ.

2.8 Сумын соёлын төвийн үйл ажиллагааны талаар :

Тус сумын соёлын төв нь 2015 онд эрхлэгч, хөгжмийн багш, номын санч, техникч, үйлчлэгч, галч гэсэн орон тоотойгоор нь төрөөс соёлыг хөгжүүлэх талаар баримтлаж буй бодлого, Засгийн газрын хөтөлбөр, засаг даргын мөрийн хөтөлбөрт соёл урлагийн талаар дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажиллажээ.

Соёлын төвийн ерөнхий менежер 2015 онд төсвийн ерөнхийлөн захирагчтай бүтээгдэхүүн нийлүүлэх үр дүнгийн гэрээ байгуулан ажиллаж үр дүнгийн гэрээгээ 97 хувиар ханган биелүүлэн “А” үнэлгээ авч аймагт 1 дүгээр байранд оржээ.

Тус байгууллага нь тайлант онд улсын төсвөөс 51,9 сая, өөрийн орлогоор 5,0 сая нийт 56,9 сая төгрөгийн орлого бүрдүүлж зарцуулахаас гүйцэтгэлээр төсвөөс 50,1 сая төгрөг, өөрийн орлогоор 4,5 сая төгрөг нийт 54.7 сая төгрөгийн орлого бүрдүүлэн зарцуулсан байна. Шилэн дансны тухай хуулийн хүрээнд зохих мэдээллийг бүрэн оруулж байршуулсан байна.

2015 онд Соёлын төв нь соёл урлагийн үйлчилгээ үзүүлэх, уран сайханчид болон ардын авъяастнуудын хүрээнд шинээр концерт найруулан тоглолт хийх, нийтийн цэнгээнт бүжиг явуулах, алдар тэмдэглэх, үдэшлэг уулзалт зохион байгуулах, 60-н жилийн ойн концертыг бүрэн хариуцан ардын авъяастнуудын бүрэн хэмжээний тоглолт хийж, хөдөөгийн багуудаар соёлын арга хэмжээг явуулах зэрэг арга хэмжээг давхардсан тоогоор 174 удаа явуулжээ.

Байгууллагад дээрхи ололттой талууд байгаа нь сайшаалтай боловч цаашид анхаарч ажиллах дараах зөрчил дутагдлууд илэрч байна.

- Соёлын төвийн үндсэн үйл ажиллагааны нэг нь соёлын үйлчилгээ боловч үнэт цаасны тооцоо хэвлүүлэн дугаарлаж тооцоо бодоогүй бөгөөд нягтлан бодогч няравын тооцоог сар бүр бодоогүй байна.
- Тайлант жилд 743,2 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг ажилчдаас суутган авсан боловч төсөвт төвлөрүүлээгүй байгаа тул нийгмийн даатгалд хандан шимтгэлийг төлж ажилтануудын дэвтэрт бичилт хийх зөвлөмж өглөө.
- НББ-ийн тухай хуулийг мөрдөөгүйгээс 1,3 сая төгрөгийн анхан шатны баримтын иж бүрдэл бүрэн болоогүй байхад зардал гаргасан байна.

Мөн өөрийн орлогыг харилцахаар дамжуулан зарцуулсан боловч 2,7 сая төгрөгийг багш хөлсөлж хүүхдэд бүжиг, хөгжим заасан гэх боловч анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлээгүй, гэрээ дүгнээгүй, хийсэн ажлын тайлан байхгүй байгаа нь төсвийн үр өгөөжийг бууруулсан байна.

- Сумын засаг даргын 2015 оны 02-р сарын 01-ны Б/02 тоот захирамжаар 3-н сарын арга хэмжээ авагдсан эрхлэгч С.Дэжидийн цалингын 20%-ийн суутгалыг 2 сар суутгаад 1 сар суутгаагүй орхисон 110,1 мянган төгрөгийг суутган авах төлбөрийн акт бичлээ.

Гүйцэтгэлийн аудитаар цалингийн суутгалыг бүрэн суутгаагүй, НДШ-ийг бүрэн төвлөрүүлээгүй 0,8 сая төгрөгийн төлбөрийн акт бичиж, үнэт цаасны тооцоо бодоогүй, үлдэгдэлийг баталгаажуулаагүй, шатахууны тооцоо бодож замын хуудас бичээгүй, няравын тайлан заавар журмын дагуу гаргаагүй 4,1 сая төгрөгийн албан шаардлага өглөө.

2.9 Сумын эмийн эргэлтийн сангийн талаар:

Эмийн эргэлтийн сан нь Эрүүл мэндийн сайдын 2011 оны 09 дүгээр сарын 16-ны өдрийн 297 тоот тушаалын хавсралтаар “Эмийн эргэлтийн сангийн ажиллах журам”-аар зохицуулагдаж байна.

Энэ журмын 2.2-т “Бүх шатны Засаг даргын бүрэн эрхийн хүрээнд удирдах болон хяналтын зөвлөлийн тухайн шатны Засаг даргын шийдвэрээр байгуулна” 2.1-д...”суманд ЭЭС-ийн үйл ажиллагаанд хяналт тавих үүрэг бүхий хяналтын зөвлөл байна.” 4.5.1-т “ЭЭС-ийн эрхлэгч нь улсын бүртгэлд бүртгэгдсэн, чанарын баталгаатай боломжийн үнэтэй эм, эмнэлгийн хэрэгслэлээр сумын эрүүл мэндийн төв, ард иргэдийг хангана” гэж заасан байна. Гэвч аудитын шалгалтын хугацаанд сумын ЭЭС-ийн үйл ажиллагааны тайлан, санхүүгийн баримтыг хянуулахыг шаардсан ч хамрагдсангүй.

Гэтэл тус эмийн санд 2015 онд ОНХС-гаас 5,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгож засвар хийсэн, 25,0 сая төгрөгийн СХС-гийн зээл олгож орон нутгаас дэмжлэг үзүүлсэн байна.

Тус эмийн эргэлтийн сан нь даатгалын сангаас авах санхүүжилт, тендерийн эм барьсны орлого, иргэдэд эм борлуулсаны орлогоос сумын иргэдэд эм эмнэлэгийн хэрэгсэлээр ханган тусламж үйлчилгээг үзүүлж байгаа ч хийгдсэн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, зээлийн хөрөнгийн зарцуулалт хангалтгүй байна.

БҮЛЭГ 3. ДОТООД ХЯНАЛТЫН ТАЛААР

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Төсвийн Ерөнхийлөн захирагчийн багцаас сумын төрийн төрийн санд олгож Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавьж байна.

Хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалтанд санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий санхүүгийн дотоод хяналтыг төсвийн шууд захирагч нар болон төрийн сангийн төлөөлөгч хэрэгжүүлж хяналт тавьж ажиллаж байна.

Санхүүгийн албаны даргыг авч ажилуулаагүйгээс төрийн сангийн төлөөлөгч хавсран гүйцэтгэж байгаа нь тоот журмын хэрэгжилт хангалтгүйгээс хяналтыг чиг үүргийг хэрэгжүүлэх 1 албан тушаалтан ажиллаагүй байна.

Сумын Төрийн сангийн мэргэжилтэний гүйлгээг хянахад сар бүрийн мемиралийн баримтыг дараалалын дагуу үдээгүй, зарим төлбөрийн даалгавар

дутуу, он сар өдөр зөрүүтэй, төрийн сангийн журамд заасан хугацаанд гүйлгээ хийгээгүй, 1 дүгээр гарын үсэг дутуу, тамга тэмдэггүй зэрэг алдаа байна.

Сумдын нийт байгууллагуудын 2015 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар орон нутгийн нэгтгэсэн тайлан, сумын соёлын төв, эрүүл мэндийн төв “Зөрчилгүй” санал дүгнэлт, сургууль, цэцэрлэг “Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан үзэхэд санхүү бүртгэлд тавих хяналт зарим байгууллагуудад хангалтгүй хэрэгжиж байгааг харуулж байна.

Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг shilendans цахим хаягаар оруулах үүргийг төсвийн байгууллагуудын захирал, нягтлан бодогч нар хэрэгжүүлж байна.

Сумын сургууль, цэцэрлэг, соёлын төвийн шилэн дансны хуульд заасан мэдээлэлүүдээс цөөн тооны мэдээлэлийг хугацаа хоцруулан оруулсан ч нийт мэдээлэл оруулалтын түвшинд хангалттай хэмжээнд тайлагнаж хэвшиж байна.

Сумын ЗДТГ, ИТХ, ОНХС, Эрүүл мэндийн төвүүдийн 2015 оны мэдээлэлийг нөхөж оруулаагүй, 2016 оны мэдээлэлээс зөвхөн сар бүрийн төсвийн гүйцэтгэлийг зөвхөн оруулсан байна. Мөн 5,0 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын гүйлгээ, аудитын дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, бусад тухай бүрт тавих мэдээлэлийг заасан хугацаанд оруулаагүй байна.

Сумын төсвийн ЗДТГ, ИТХ, ОНХС, Эрүүл мэнд төвийн мэдээлэлийг Шилэн дансны сайтад байршуулах, мэдээлэх эрх бүхий албан хаагчид хуульд заасан чиг үүргээ биелүүлээгүй тул хариуцлага тооцож хариу мэдэгдэх албан шаардлагыг хүргүүллээ.

Харин сум хөгжүүлэх сангийн мэдээлэлийг оруулах цэсийг тусад нь байршуулаагүйгээс мэдээлэлийг оруулаагүй тул бусад дутуу оруулсан тул нэмж оруулахыг зөвлөмж болголоо.

Орон нутгийн олон нийтийн ТВ /Ховд ТВ/, Орон нутгийн сонин /Ховдын толь сонин/, танилцуулга, бусад олон нийтийн ажил, уулзалт, сургалт, багуудын хурлаар дамжуулан сум орон нутагт хийгдэж буй хөрөнгө оруулалт, санхүүжилт, ажлын гүйцэтгэлийн талаар олон нийтэд хүргэн ажиллаж байна.

Мэдээлэлийн технологийн эрин үед хэрэглэж буй нягтлан бодох бүртгэлийн программ хангамжийг иж бүрэн ашиглах шаардлагатай байна.

2015 онд Шуудан холбооны газартай гэрээ байгуулан сумдын байгууллагууд цахим сүлжээнд холбогдсон, мэдээлэл түгээх үүрэн холбооны сүлжээ өргөн тархсан зэргээс үзэхэд цахим мэдээлэлийг тухай бүр ашиглах боломжтой болжээ.

Сумын бүх төсөвт байгууллагууд санхүүгийн программ хангамж ашиглаж байгаа боловч бараа материалын тайланг иж бүрнээр программд оруулдаггүй, цалинг программ хангамж ашиглан боддогүй зөрчил байна.

Аудитаар нийт 83,635,200 төгрөгний төлбөр зөрчил илэрсэнээс 4,656,516 төгрөгт актыг аймгийн төсөвт төвлөрүүлэх, 39,000,000 төгрөгийн СХС-д буцаан төлүүлэх, 6,328,827 төгрөгийг байгууллага, ажилчдад буцаан олгох, 33,649,857 төгрөгт албан шаардлага бичигдлээ.

ЕРӨНХИЙ ДҮГНЭЛТ

Тус сумын орон нутгийн төсөвт байгууллагууд 2015 онд дэвшүүлсэн зорилтоо хэрэгжүүлэн ажилласан боловч санхүү бүртгэлээр тавих дотоод хяналт сул, Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүнд илэрсэн төлбөр, зөрчилд үндэслэн дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг дараах албан тушаалтануудад зөвлөмж болгон хэрэгжүүлж байна.

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын дарга Даариймаа, Засаг дарга Х.Дэлгэрнасан нарт

- Сум хөгжүүлэх сангийн зээлийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлж, зээлээ графикт хугацаандаа төлөөгүй, зориулалт бусаар зарцуулж буй иргэдийн зээлийг буцаан татаж зээлийн эргэлтийг нэмэгдүүлэх
- Орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгийн ашиглалт, эзэмшилт, хадгалалт, хамгаалалтанд тавих хяналтыг сайжруулах талаар тодорхой арга хэмжээ зохион байгуулах
- Сумын түүхт 60 жилийн арга хэмжээний нэгдсэн тайланг гаргаж бүх багуудын ИНХуралд танилцуулж хэлэлцэх
- Сумын засаг даргын тамгын газрын бүтцийн дагуу ажилтануудыг ажилд ажлын байрны тодорхойлолтонд заасан чиг үүргийг

Сургуулийн захирал Ц.Мөнхбатад

- Дотуур байрны багш, тогооч нарын ажлын хариуцлагыг дээшлүүлэх, хүүхдийн ирцийг үнэн зөв бүртгэж хэвших, хоолны норм нормативыг мөрдөн ажиллах
- Санхүүгийн программ ашиглалтыг сайжруулах, мэдээллийг үнэн зөв оруулж санхүүгийн тайланг программаар гаргаж хэвших
- Үдийн цай хөтөлбөрийн хэрэгжилт, жижүүр багшийн ирцийн бүртгэлд сургуулийн удирдлага болон эмч, санхүүгийн ажилтны тавих хяналтыг сайжруулах, холбогдох албан тушаалтны ажлын хариуцлагыг дээшлүүлэх
- Сургуулийн цайны газартай түрээсийн гэрээ байгуулж орон нутгийн өмчийн хөрөнгийн ашиглалтын сайжруулах

Сумын цэцэрлэгийн эрхлэгч Ц.Цогзолмаад:

- Багш ажилчдад ажлын үр дүнг харгалзан ур чадварын нэмэгдэл, илүү цаг, үр дүнгийн нэмэгдлийг олгож төсвийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлж ажиллах
- Хүүхдийн хоолны амт чанар, хоолны илчлэг, нэр төрөлд анхаарч БСШУСайдын 225/296 тоот тушаалаар баталсан хоолны норм, үндсэн шимт бодисын илчлэгийн хэрэгцээг мөрдөж ажиллах, хүүхдийн хоолны ирцэд тавих хяналтыг сайжруулах
- Анги танхим, гадна орчны цэвэр цэмцгэр байдал, тохижилтонд анхаарч багш ажилчидын бүтээлч сэтгэлгээг хөгжүүлж ур чадварыг дээшлүүлэхэд

анхаарч гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчилж сайжруулах арга хэмжээ авах

Сумын эрүүл мэндийн төвийн эрхлэгч Б.Бямбасүрэнд:

- Төлбөртэй үйлчилгээний орлогыг сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулж иргэдэд үйлчилгээг хүргэн яаралтай оношилгоо хийдэг ажлыг нэвтрүүлэх
- Шатахуун, эмийн зарцуулалтанд тавих хяналтыг сайжруулах

Сумын соёлын төвийн эрхлэгч С.Дэжид:

- Үнэт цаасны тооцоог сар бүр хийж үлдэгдэлийг баталгаажуулан, тайз ашигласан шимтгэлийн орлогын мөнгө хураасан баримтыг дарга, нягтлан бодогч, няравын гарын үсгээр баталгаажуулж баримтжуулах
- Анхан шатны баримтыг бүрдүүлж, нягтлан бодох бүртгэлээр тавих хяналтийг сайжруулж, өр төлбөр, бараа материалын тайланг стандартын дагуу гаргаж хэвших

ТАЙЛАНТАЙ ТАНИЛЦСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.ГАЛБАДРАХ

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

А.ЦЭЦЭГСҮРЭН

АХЛАХ АУДИТОР

Д.НАРАНТУУЛ

АУДИТОР

Д.ЭРДЭНЭЦЭЦЭГ

ШИНЖЭЭЧ

Б.ДАМЧУУБАЛЖИР

Тэргүүлэх Аудиторын тушаал:



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬАА
ХОВД АЙМГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2016 оны 10 сарын 05 өдөр Дугаар 26 Хонд 101

Аудитын тайлан, зөвлөмж, акт,
албан шаардлага батлах тухай

Төрийн Аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.7, 15 дугаар зүйлийн 15.1.12 дугаар заалт Монгол Улсын Ерөнхий аудиторов 2003 оны 53 тоот тушаалаар баталсан "гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2, 2009 оны 47 тоот тушаалаар баталсан "төлбөрийн акт тавих, албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 2.1 дэх заалт, аймгийн Аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторов дэргэдэх зөвлөлийн 2016 оны 10 сарын 05-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ нь:

1. Дөргөн, Мянгад сумдын төсөвт байгууллагуудын 2015 оны үйл ажиллагааны үр дүнд хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлан, зөвлөмж, акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
2. Гүйцэтгэлийн аудитын дүн дүгнэлтэнд үндэслэн Дөргөн сумын Засаг дарга Х.Дэлгэрнасан-д ДААЛГАХ нь:
 - 2.1 Сум хөгжүүлэх сангийн зээлийн хөрөнгийн үр өгөөжийг нэмэгдүүлж, зээлээ графикт хугацаандаа төлөөгүй, зориулалт бусаар зарцуулж буй иргэдийн зээлийг буцаан татаж зээлийн эргэлтийг нэмэгдүүлэх
 - 2.2 Орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгийн ашиглалт, эзэмшилт, хадгалалт, хамгаалалтанд тавих хяналтыг сайжруулах талаар тодорхой арга хэмжээ зохион байгуулах
 - 2.3 Сумын түүхт 60 жилийн арга хэмжээний нэгдсэн тайланг гаргаж бүх багуудын ИНХуралд танилцуулж хэлэлцэх
3. Мянгад сумын Засаг дарга Б.Даваадорж-д ДААЛГАХ нь:
 - 3.1 СХСангаас авсан зээлээ бүрэн төлөөгүй байгаа иргэдээс зээлийн үндсэн төлбөрийн үлдэгдэл болох 108,6 сая төгрөгийг төлүүлэн авч дараагийн зээлдэгч нарт олгох
 - 3.2 Төрийн үйлчилгээний түгээмэл мэргэжлийн алба хаагчидад ур чадварын нэмэгдлийг олгох журмыг баримтлан олгох

3.3 Гадны машинаар гүйцэтгэсэн 2,4 сая төгрөгний шатахуун зарцуулалтын тайлан, жолоочийн замын хуудас бичиж хэвших

4. Гүйцэтгэлийн аудитын зөвлөмж тавьсан акт, албан шаардлагыг барагдуулж дүнг 11 сарын 10-ны дотор танилцуулахыг аудит хийсэн аудитор, шинжээч нарт хариуцуулсугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Л.ГАЛБАДРАХ

